



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/531

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Оргил багийн нутаг дэвсгэрт “Хонгор буурал” ХХК-ийн хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан 6 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Алтанзагас	-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	М.Мандаххүү	-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ц.Амарсанаа	-(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал	-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг	-(Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Г.Хүрэлхүү	-(“Ундарга-Алтай” ААТҮГ-ын ерөнхий инженер)

C:/My documents/-3A-4 doc

0201001805


2.

- Б.Бээжин -("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)
- С.Наранбаяр -("Мандал-Голомт" ХХК-ийн ерөнхий инженер)
- А.Алтанхуяг -(Есөнбулаг сумын Засаг дарга)
- Н.Пүрэвдулам-(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер)
- Ч.Нарандэлгэр-("Барилга байгууламж" ХХК-ийн захирал) (зохиогч)
- Ш.Ариунаа -(Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны аймгийн зөвлөлийн тэргүүн)

Нарийн бичгийн дарга:О.Доржнамжим-(“Хонгор буурал” ХХК-ийн инженер)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР